



ДУНДГОВЬ АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН
ДЭРГЭДЭХ СТАТИСТИКИЙН ХЭЛТЭС

**БАРИЛГА,
АЖ ҮЙЛДВЭРИЙН
ТАНИЛЦУУЛГА
2017 ОН**



www.dundgovi.nso.mn

УТАС: 70593715, 70593714

Агуулга

- Оршил, түүхэн замнал
- Аж үйлдвэр
 - уул уурхай олборлох салбар
 - Боловсруулах аж үйлдвэр
 - Цахилгаан, дулааны эрчим хүч үйлдвэрлэл, усан хангамж
- Барилга
- Тээвэр холбоо, дэд бүтэц
- Бүртгэлтэй аж ахуй нэгж
- Дотоодын нийт бүтээгдэхүүн
 - аж үйлдвэр, барилгын салбарын дотоодын нийт бүтээгдэхүүн
 - Аймгийн 1 хүнд ноогдох дотоодын нийт бүтээгдэхүүн
- Дүгнэлт

Оршил

Энэхүү танилцуулга нь Дундговь аймгийн аж үйлдвэр үйлчилгээний салбар 2017 онд хэрхэн өсч хөгжсөн аймаг орон нутгийн эдийн засгийн хөгжилд ямар хувь нэмэр оруулсан, үйлдвэр, барилгын салбарын статистик үзүүлэлтүүдийг нэгтгэн бодлого боловсруулагчидад хүргэх зорилготой юм.

Аж үйлдвэрийн салбар нь уул уурхай олборлох салбар, боловсруулах аж үйлдвэр мөн цахилгаан, дулааны эрчим хүч үйлдвэрлэл, усан хангамж гэсэн дэд бүлгүүдээс бүрддэг ба танилцуулгад орсон тоо мэдээллийн эх сурвалж нь аж үйлдвэрийн сар, улирал, жилийн мэдээ тайлан юм.

Ойлголт тодорхойлолт

Аж үйлдвэрийн салбарын үйл ажиллагааг аж ахуйн нэгж, байгууллагын ажиллагчид, зардал, бүтээгдэхүүн үйлдвэрлэлийн хэмжээ, борлуулалт, үндсэн хөрөнгө болон санхүүгийн үндсэн үзүүлэлтүүдээр илэрхийлж, аж ахуйн нэгжийн сар, жилийн тайлан, тооллого судалгааны үр дүнгийн тоон мэдээллийг ашиглан тэдгээрийг нэгтгэн гаргадаг.

Бүтээгдэхүүн гэж үйлдвэрлэлийн үр дүнд бий болсон бараа, үйлчилгээг хэлнэ.

Үйлдвэрлэл нь тухайн аж ахуйн нэгжийн зах зээлд болон өөрийн эцсийн хэрэглээнд зориулж үйлдвэрлэсэн бүтээгдэхүүнээс бүрдэнэ.

Гол нэр төрлийн бүтээгдэхүүн гэж тайлант хугацаанд үйлдвэрлэсэн салбарын үйлдвэрлэлийг төлөөлөхүйц бүтээгдэхүүнийг хэлнэ.

Борлуулалт нь Тайлангийн хугацаанд худалдсан буюу гадагш гүйцэтгэсэн ажил үйлчилгээ, бүтээгдэхүүний борлуулалтыг хэлнэ.

Хэд хэдэн төрлийн бүтээгдэхүүн үйлдвэрлэж, ажил үйлчилгээ эрхэлдэг аж ахуй нэгжийг өндөр хувийн жинтэй бүтээгдэхүүн, ажил үйлчилгээгээр нь холбогдох салбарт хамруулна.

Цахилгаан станц, нүүрсний уурхайн мэдээг үндэслэн цахилгаан, дулаан эрчим хүч, нүүрсний тэнцлийг жилд нэг удаа нэгтгэн гаргадаг.

Үйлдвэрлэсэн, импортлосон цахилгаан эрчим хүч, нүүрсний хэмжээ, цахилгаан станцын дотоод хэрэглээ, түгээлтийн болон шугамын алдагдал, хуваарилалтыг эдийн засгийн үйл ажиллагааны голлох салбараар ангилж, биет хэмжээгээр тэнцэлд тусгаж байна.

Салбарын түүхэн замнал

Аймгийн хөгжлийн эхний 50 жил буюу социализмын үеийн хөгжлийн жилүүдэд олсон томоохон амжилтуудын нэг нь орчин үеийн аж үйлдвэрийн салбар үүсч хөгжсөн явдал юм. Тус аймагт 1942 онд нийтийн хоол боловсруулах гуанз байгуулагдсанаар хүнсний болон аж үйлдвэрийн суурь тавигджээ. Улмаар энэ нь өргөжиж 1974 он гэхэд 4 тасагтай 50 гаруй ажилтантай болж жилдээ 1.4 сая төгрөгийн бүтээгдэхүүн үйлдвэрлэж, 6 сая төгрөгийн борлуулалт хийж байв. 1986 онд талх, нарийн боов, гоймон, архи, ундаа, сүү боловсруулж үйлдвэрлэх үндсэн 6 цехтэй шинэ үйлдвэр ашиглалтанд орсон байна.

Үүнээс хойш 1949 онд аймгийн үйлдвэр хоршооллын артельд 1 мужаантай мод боловсруулах үйлдвэрийн суурь, 1948 онд гар ажиллагаатай хэвлэх үйлдвэр мөн 1961 оны 10 сарын 19-нд Эрдэнэдалай сумын нутаг Элэгний говийн нүүрсний ордод түшиглэн Цагаан овоогийн нүүрсний уурхайг 19 ажилтан, 5 гэр, 2 машинтай ашиглалтанд оруулснаар уул уурхай, олборлох салбарын суурь тус тус тавигдсанаар тус аймагт аж үйлдвэрийн салбар хөгжиж байсан байна. 1990

оны нийгэм эдийн засгийн өөрчлөлтөөр эдгээр үйлдвэрүүд хувьд шилжин ажиллаж байна.

1. Аж үйлдвэр




Дундговь аймгийн аж үйлдвэрийн бүтээгдэхүүн үйлдвэрлэлт 2017 онд /оны үнээр/ нийт 8097.8 сая төгрөг болсон байна. Энэ нь өмнөх онтой харьцуулахад 12.0 хувиар буюу 864.7 сая төгрөгөөр өссөн үзүүлэлт юм. Дээрх өсөлтөнд цахилгаан дулааны эрчим хүч үйлдвэрлэл, усан хангамж үйлдвэрлэл өмнөх онтой харьцуулбал 24.3 хувиар өссөн нь голлон нөлөөлсөн байна. Мөн тухайн онд өмнөх онтой харьцуулбал боловсруулах аж үйлдвэрийн салбар 1.5 хувиар, уул уурхайн олборлох салбар 3 хувиар тус бүр өссөн байна. 2017 оны байдлаар аж үйлдвэрийн бүтээгдэхүүн үйлдвэрлэлтийн 47.9 хувийг цахилгаан, дулааны эрчим хүч үйлдвэрлэл, усан хангамж, 37.7 хувийг уул уурхайн олборлох аж үйлдвэр, 14.5 хувийг боловсруулах аж үйлдвэр тус тус эзэлж байна. Үйлдвэрийн салбарын бүтцийн өөрчлөлтийг сүүлийн 5 жилээр харууллаа. Зураг.1-т Аж үйлдвэрийн салбарын сүүлийн 5 жилийн бүтцийн өөрчлөлтийг дэд салбаруудаар харууллаа.

Хүснэгт-1. Аж үйлдвэрийн нийт бүтээгдэхүүн үйлдвэрлэлт/дэд салбараар, сая.төг/

Аж үйлдвэрийн салбар	2013	2014	2015	2016	2017	2017/2016 хувь
Нийт дүн	4360.8	6349.9	7543	7233.1	8097.8	112.0
Уул уурхайн олборлох аж	1209.5	3098.5	4034	2959.9	3049.5	103.0
Нүүрс олборлолт	250.6	327.0	393.7	500.6	379.9	75.9
Гөлтгөнө	-	-	876	233.6	676.9	289.8
Жонш олборлолт	958.9	2771.5	2764	2225.7	1992.7	89.5
Боловсруулах аж үйлдвэр	1164.7	1264.0	1059	1152.9	1170.4	101.5
Хүнсний бүтээгдэхүүн, ундаа үйлдвэрлэл	609.9	649.6	653.6	836.7	879.6	105.1
Хуснэгт маягт үйлдвэрлэл	14.7	13.8	17.6	14.7	19.1	129.9
Боловсруулах бусад үйлдвэр	540.1	600.6	388	301.5	271.7	90.1
Цахилгаан дулааны эрчим	1986.6	1987.4	2450	3120.3	3877.9	124.3
Цахилгаан, дулаан, уур үйлдвэрлэл	1607.8	1599.5	1947	2605.4	3200.4	122.8
Ус ариутгал ус хангамж	378.8	387.8	502.6	514.9	677.5	131.6

Зураг.1/

Аж үйлдвэрийн салбарын бүтэц /хувиар, сүүлийн 5 жилээр/



1.1 Уул уурхай олборлох аж үйлдвэр

2018 оны 1 дүгээр сарын 04-ний байдлаар Дундговь аймгийн нутаг дэвсгэрт ашигт малтмалын ашиглалтын тусгай зөвшөөрөл 13 сумын нутагт 95, хайгуулын тусгай зөвшөөрөл 15 сумын нутагт 136, нийт 231 тусгай зөвшөөрөл байгаа бөгөөд эдгээрийн нийт талбайн хэмжээ 1,004.5 мянган га буюу нийт нутаг дэвсгэрийн 13,4 хувийг эзэлж байна.

Хүснэгт-2. Ашиглалт хайгуулын зөвшөөрөл олгосон байдал /сумаар/

Сумын нэр	Ашиглалтын тусгай зөвшөөрөл		Хайгуулын тусгай зөвшөөрөл		Бүгд	Талбайн хэмжээ	Газар нутгийн хэдэн хувийг эзлэх
	тоо	Талбай	тоо	Талбай		Мян.га	
		Мян.га		Мян.га			
1. Дэлгэрцогт	-	-	2	60.9	2	60.9	0.9
2. Дэрэн	-	-	5	78	5	78	1.2
3. Говь-Угтаал	11	7.5	7	17.9	18	25.5	6.3
4. Цагаандэлгэр	3	4.6	6	11	9	15.6	9
5. Баянжаргалан	29	40.4	14	27.7	43	68.1	14.9
6. Өндөршил	7	40.9	21	169.9	28	210.8	45.1
7. Гурвансайхан	15	71.8	14	77.2	29	149.1	24.7
8. Өлзийт	9	62.2	29	159.9	38	222.1	9.6
9. Хулд	3	6	20	160.6	23	166.6	25
10. Луус	2	0.4	10	86	12	86.4	11.2
11. Дэлгэрхангай	18	8.5	13	69.8	31	78.3	16.6
12. Сайхан-Овоо	1	1.4	1	3.7	2	5.1	1.2
13. Эрдэнэдалай	6	5.8	10	102.9	16	108.7	19.6
14. Сайнцагаан	4	3.2	3	8.9	7	12.1	1.6
15. Адаацаг	2	0.3	2	2	4	2.3	0.9
Дүн/давхардаагүй тоогоор/	95	156.4	136	848.1	231	1,004.50	13.4

Ашиглалтын 95 тусгай зөвшөөрөлийн 28 нь жоншны, 21 нь нүүрсний /7 орд/, 13 нь гөлтгөний /3 орд/, 12 нь барилгын материалын, 7 нь төмрийн, 8 нь алтны, 2 нь өнгөт металлын, 1 нь бал чулууны орд газар байна. Эдгээрийг 61 аж ахуйн нэгж эзэмшиж байгаагийн дотоодын хөрөнгө оруулалттай-40, хамтарсан хөрөнгө оруулалттай-8, гадаадын 100% хөрөнгө оруулалттай-13 байна.

Хайгуулын 136 тусгай зөвшөөрлийг 119 аж ахуйн нэгж эзэмшиж байгаагийн дотоодын хөрөнгө оруулалттай-110, хамтарсан хөрөнгө оруулалттай-2, гадаадын 100 хувь хөрөнгө оруулалттай-7 аж ахуй нэгж байна.


Хүснэгт.3. Ашигт малтмалын тусгай зөвшөөрөл олгогдсон байдал

Он	Ашиглалтын тусгай зөвшөөрөл		Хайгуулын тусгай зөвшөөрөл		Бүгд	Талбайн хэмжээ Мян.га	Газар нутгийн хэдэн хувийг эзлэх
	тоо	Талбай Мян.га	тоо	Талбай Мян.га			
2014	73	67.8	120	727	193	794.8	10.63
2015	79	127.2	171	1098.1	250	1,225.30	16.4
2016	80	124	150	929.4	230	1,053.40	14.1
2017	95	156.4	136	848.1	231	1,004.50	13.4

Уул уурхай, олборлох аж үйлдвэрийн нийт бүтээгдэхүүн үйлдвэрлэлт 2017 онд 3049.5 сая төгрөг болж өмнөх онтой харьцуулахад 3 хувиар буюу 89.6 сая төгрөгөөр өссөн байна./Зураг.2/ Гол нэр төрлийн бүтээгдэхүүнүүдийг өмнөх онтой харьцуулахад гөлтгөнө биет хэмжээгээр 5.2 дахин, мөнгөн дүнгээр 2.9 дахин тус тус өссөн бол нүүрс биет хэмжээгээр 16.4 хувиар, мөнгөн дүнгээр 24.1 хувиар буурсан, жонш олборлолт биет хэмжээгээр 56.7 хувиар, мөнгөн дүнгээр 10.5 хувиар буурсан байна.

/Зураг.2/

Уул уурхайн гол нэр төрлийн бүтээгдэхүүн/сая.төг/



Хүснэгт-4. Уул уурхайн гол нэр төрлийн бүтээгдэхүүн

Нэр төрөл	Хэмжих нэгж	2013	2014	2015	2016	2017	2017/2016 хувь
Уул уурхай олборлох аж үйлдвэр							
Нүүрс	мян.тн	16,0	16.6	17.6	18.3	15.3	83.6
Гөлтгөнө	мян.тн	-		12.7	7.3	38.1	521.9
Жонш	мян.тн	13,5	30	32.6	26.8	11.6	43.3

2017 онд ашигт малтмалын нөөцийн төлбөрөөс орон нутгийн төсөвт 1465.4 сая төгрөг, усны төлбөрөөс 22.8 сая.төгрөг, газрын төлбөрөөс 128.8 сая.төгрөгийн орлого орсон байна.

Хүснэгт-5.Ашигт малтмалын тусгай зөвшөөрлөөс төсөвт орсон төлбөр

№	Нэр төрөл	Хэмжих нэгж	2013	2014	2015	2016	2017
1	Ашигт малтмал ашигласны нөөцийн төлбөр	Сая.төг	814.3	876.9	784.1	-	1465.4
2	Газрын төлбөр	Сая.төг	120	131	149	160.5	128.8
3	Усны төлбөр	Сая.төг	27.1	25.8	34.1	29.9	22.8

1.2 Боловсруулах аж үйлдвэр

Боловсруулах аж үйлдвэрийн салбарын нийт үйлдвэрлэл 2017 онд 1170.4 сая төгрөг болж, өмнөх онтой харьцуулахад 1.5 хувиар өссөн байна. Тус салбарын энэхүү өсөлтөнд хүнсний бүтээгдэхүүн, ундаа үйлдвэрлэл өмнөх онтой харьцуулбал 5.1 хувиар, хүснэгт маягт үйлдвэрлэл 30.1 хувиар тус тус өссөн нь голлон нөлөөлсөн байна. Харин боловсруулах үйлдвэрийн бусад үйлдвэрлэл 9.9 хувь буюу 29.8 сая.төгрөгөөр буурсан байна. Боловсруулах аж үйлдвэрийн гол нэр төрлийн бүтээгдэхүүнүүдийг сүүлийн 5 жилээр өсөлт бууралтыг хүснэгт-6 д харууллаа.


Хүснэгт-6. Боловсруулах аж үйлдвэрийн гол нэр төрлийн бүтээгдэхүүн/биет хэмжээгээр/

Гол нэр төрлийн бүтээгдэхүүн	Хэмжих нэгж	2013	2014	2015	2016	2017	2017/2016 хувь
Хүснэгт маягт	м,х,д,х	210.7	197.1	250.5	210.1	272.9	129.9
Талх	тн	75.3	89.5	99.5	115.2	116.8	101.4
Нарийн боов	тн	102.4	93.1	98.7	112.8	115.4	102.3
Чихэр	тн	1.5	1.8	2.5	2.5	3.4	136.0
Бялуу	тн	0	0.9	2.3	3.7	1.1	29.7
Архи	мян.л	27	18.5	17.1	27.1	27.9	103.0
Ундаа	мян.л	4.3	1.6	1.4	2	1.7	85.0
Цэвэр ус	мян.л	5	5.7	8.4	7	15.4	220.0
Гоймон	тн	28.8	23.8	20.6	20.2	20.4	101.0
Хэрчсэн гурил	тн	5	9.4	8.8	9.1	9.6	105.5
Хиамны зүйл	тн	4	1.7	1.5	0.4	0.4	100.0
Тараг	мян.л	11.7	18.2	9.3	12.9	5.4	41.9
Хоормог	мян.л	1.1	0.6	0.2	0.7	0.7	100.0
Ааруул	тн	0.7	1.5	1.6	1.1	0.9	81.8
Вакум хаалга,цонх	м2	493	812	331	500	220	44.0
Блок	мян.ш	45.6	78.6	28.7	41.6	20	48.1
Оёдол эсгүүр	мян.төг	281756	194144	76204	92103	67765	73.6
Модон эдлэл үйлдвэрлэл	мян.төг	120714	144975	214948	208273	102643	49.3

Боловсруулах аж үйлдвэрийн нийт үйлдвэрлэлийг бүтцээр нь авч үзвэл хүнсний бүтээгдэхүүн үйлдвэрлэл 75.2 хувь, хэвлэх үйлдвэр 1.6 хувь, боловсруулах үйлдвэрийн бусад салбарын үйлдвэрлэл 23.2 хувийг тус тус эзэлж байна. Энэ нь өнгөрсөн онтой харьцуулахад хүнсний үйлдвэрлэлийн эзлэх хувь 2.5 пунктээр, хүснэгт маягт үйлдвэрлэлийн эзлэх хувь 0.3 пунктээр өссөн үзүүлэлт бол харин боловсруулах үйлдвэрлэлийн бусадын эзлэх хувь 2.9 пунктээр буурсан үзүүлэлттэй байна. /Зураг.3/

/Зураг.3/

Боловсруулах аж үйлдвэрийн бүтээгдэхүүн /салбар ангиллаар, сая.төг/



Аймгийн боловсруулах бусад сарбарын үйлдвэрлэлийн дийлэнх хувийг жижиг дунд бизнес эрхлэгчид үйлдвэрлэж байна.

Монгол улсын төрөөс жижиг дунд бизнесийг дэмжих зорилгоор тогтмол хэрэгжүүлдэг сангуудын мэдээллийг харвал “Жижиг дунд бизнесийг дэмжих сан” сүүлийн 2 жил буюу 2016, 2017 онд тус аймагт зээл олгоогүй, харин сум хөгжүүлэх сан тогтмол зээл олгосон байна. Сум хөгжүүлэх сан 2017 онд аймгийн хэмжээнд 131 төсөлд 1197.6 сая төгрөгийн зээлийг олгосон бөгөөд үүний үр дүнд 76 ажлын байр хадгалагдаж, шинээр 156 ажлын байр нэмэгджээ. Сум хөгжүүлэх сангийн мэдээлэлийг Хүснэгт.7 болон Зураг.4-д харууллаа.

Зураг.4

Сум хөгжүүлэх сангийн зээл олголт



Хүснэгт.7. Сум хөгжүүлэх сангийн зээл олголт, сумаар

Сум	2016 он				2017 он			
	төслийн тоо	зээлийн хэмжээ /мян.төг/	Шинэ ажлын байр	Хадгалагдсан ажлын байр	төслийн тоо	зээлийн хэмжээ /мян.төг/	Шинэ ажлын байр	Хадгалагдсан ажлын байр
Сайнцагаан	39	393000	57	38	26	555600	77	41
Луус	6	68000	2	4	11	72830	11	-
Хулд	10	39000	10	-	12	91000	12	-
Дэлгэрхангай	-	-	-	-	4	32000	4	-
Сайхан-Овоо	7	23400	8	2	11	38500	6	11
Эрдэнэдалай	2	50000	1	1	-	-	-	-
Адаацаг	23	116500	14	9	22	84500	11	11
Дэлгэрцогт	8	53000	8	-	10	69350	10	-
Дэрэн	17	46000	15	-	-	-	-	-
Цагаандэлгэр	5	30500	5	-	-	-	-	-
Говь-Угтаал	-	-	-	-	19	112200	11	8
Баянжаргалан	-	-	-	-	5	41500	5	-
Өндөршил	2	12500	1	1	6	51000	4	2
Гурвансайхан	4	14100	6	-	2	33000	2	-
Өлзийт	-	-	-	-	3	16100	3	3
Нийт	123	846000	127	55	131	1197580	156	76

1.3 Цахилгаан дулаан үйлдвэрлэл, усан хангамж

Дундговь аймгийн төв болон 14 сум бүхэлдээ төвлөрсөн эрчим хүчний системд холбогдсон бөгөөд тус аймагт Багануур-Зүүн өмнөд бүсийн Цахилгаан Түгээх Сүлжээ ТӨХК-ийн Дундговь Цахилгаан Түгээх сүлжээ салбар ажиллаж байна. Дулаан хангамжийн хувьд аймгийн төв Сайнцагаан сумын аж ахуй нэгжүүд болон аймгийн айл өрхийн хэрэглэгчдэд Ган-Илч ХХК, Тэвшийн говь ХХК болон Дундговь-Ус ОНӨУҮГ, Ариунболор ХХК-ууд дулаан үйлдвэрлэн түгээж байна. Мөн Ган-Илч компани нь 2017 онд Цагаандэлгэр, Говь-Угтаал сумдад сум тус бүрт цагт 1,2мв дулаан үйлдвэрлэх хүчин чадал бүхий GI-20, 0.6 мв дулаан үйлдвэрлэх хүчин чадал бүхий GI-14 дулааны зуух суурилуулан ажиллуулж албан газрууд болон иргэдийг дулаанаар хангаж ажиллаж байна.


Дундговь аймгийн төв болон 14 сумын нийт хүн амын цэвэр усны хэрэглээг газрын гүний усаар хангаж байна. Тус аймгийн усан хангамж болон цэвэр бохир усны хангамж ариутгалын салбарт Дундговь-Ус ОНӨҮГ дангаараа үйл ажиллагаагаа явуулж аймгийн иргэдийн эрэлт хэрэгцээг ханган ажиллаж байна. Дундговь –Ус ОНӨҮГ нь Дундговь аймгийн төв Сайнцагаан сумын хүн ам, албан газар, аж ахуй нэгжийг цэвэр усаар хангах, бохир усыг татан зайлуулж цэвэрлэн халдваргүйжүүлэх, нийтийн халуун усны ашиглалт 2.1, 0.5 хүчин чадалтай нам даралтын зуухны ашиглалтыг хариуцаж дулаан үйлдвэрлэх түгээх үйлчилгээг холбогдох тусгай зөвшөөрлүүдийн дагуу хариуцан ажилладаг 100 хувийн орон нутгийн өмчит аж ахуйн тооцоотой үйлдвэрийн газар юм.

Цахилгаан дулаан үйлдвэрлэл, усан хангамжийн салбар 2017 онд амжилттай ажиллаж нийт үйлдвэрлэлийн

хэмжээ 3877.9 сая төгрөг болж өмнөх онтой харьцуулбал 24.3 хувиар буюу 756.6 сая.төг-өөр өссөн байна. /Зураг.5/

Зураг.5

ДУЛААНЫ ЭРЧИМ ХҮЧ ҮЙЛДВЭРЛЭЛ, УСАН ХАНГАМЖ/сая.төг/



Мөнгөн дүнгээр авч үзвэл өмнөх онтой харьцуулахад дулаан үйлдвэрлэл 22.8 хувь буюу 546.9 сая төгрөгөөр, усан хангамж ариутгал 31.6 хувиар буюу 162.6 сая төгрөгөөр тус тус өссөн байна

Салбарын гол нэр төлийн бүтээгдэхүүнийг биет хэмжээгээр өмнөх онтой харьцуулвал дулааны эрчим хүч 15.3 хувиар, түгээсэн цэвэр ус 37.3 хувиар, сувагжуулалт 15.7 хувиар тус тус өсчээ.

Хүснэгт.8. Цахилгаан дулааны эрчим хүч үйлдвэрлэл, усан хангамжийн гол нэр төрлийн бүтээгдэхүүн

Үзүүлэлт	Хэмжих нэгж	2013	2014	2015	2016	2017	2017/2016 хувь
Цахилгаан дулааны эрчим хүч үйлдвэрлэл, усан хангамж							
Дулааны эрчим хүч	мян.ккл	69.9	68.1	80.7	87.8	101.2	115.3
Түгээсэн цэвэр ус	мян.м³	80	76.4	100.3	89.1	122.3	137.3
Сувагжуулалт	мян.м³	44.8	49.8	66.9	67.7	78.3	115.7


2. Барилга



Дундговь аймгийн хэмжээнд 2017 онд 8003.1 сая төгрөгийн барилга угсралт их засварийн ажил хийгдсэн нь өнгөрсөн онтой харьцуулахад 27.9 хувиар буурсан байна. Энэ онд 5517.6 сая төгрөгийн барилга угсралтын ажил, 2485.5 сая төгрөгийн их засварын ажил хийжээ. /Зураг.6./

/Зураг.6./

Барилга угсралт, их засварын ажил/сая.төг/



Энэ онд 1620.0 сая төгрөгийн орон сууцны барилга, 1462.2 сая төгрөгийн худалдаа үйлчилгээний зориулалттай барилга, 80.2 сая төгрөгийн конторын зориулалттай барилга, 459.1 сая төгрөгийн орон сууцны бус бусад барилга, 44.9 сая төгрөгийн эрчим хүчний ажил, 820.7 зам талбайн, 164,3 сая төгрөгийн далан суваг шугамын ажил, 268.3 сая төгрөгийн бусад зам талбайн ажил, 169.0 төгрөгийн орон сууцны их

засвар, 2562.1 орон сууцны бус их засварын ажил хийгдсэн байна.

/Зураг.7./

2017 оны барилга угсралтын ажил, бүтэц төрлөөр /сая.төг/



2017 онд тус аймагт өрнөсөн томоохон бүтээн байгуулалтаас дурдвал Сайхан-овоо суманд 100 ортой сургуулийн дотуур байр, Өлзийт сумын 1.5 км авто зам, явган хүний зам, аймгийн төвийн 13, болон 9-р байрны гадна фасадны ажил зэрэг барилгын ажлууд хийгдсэн байна.

Зураг.8.2017оны бүтээн байгуулалтын зурагнуудаас



3.Тээвэр холбоо



Тээвэр: 2017 оны байдлаар зорчигч тээвэр 29.3 мянга болж өмнөх оноос 32.9 хувиар буурч, зорчигч эргэлт мөн 32.8 хувиар буурч 8059.5 мян.хүн.км болсон байна. Зорчигч тээврийн орлого 31.6 сая төгрөг болж өмнөх оноос 2.6 хувиар буурсан байна.

Хүснэгт.9. Зорчигч тээврийн мэдээ

Үзүүлэлт	Хэмжих нэгж	2013	2014	2015	2016	2017	2017/2016 хувь
Цахилгаан дулааны эрчим хүч үйлдвэрлэл, усан хангамж							
Дулааны эрчим хүч	мян.кквт	69.9	68.1	80.7	87.8	101.2	115.3
Түгээсэн цэвэр ус	мян.м ³	80	76.4	100.3	89.1	122.3	137.3
Сувагжуулалт	мян.м ³	44.8	49.8	66.9	67.7	78.3	115.7

Холбоо: Дундговь аймгийн хувьд Өлзийт, Дэлгэрхангай сумдаас бусад бүх сумд шилэн кабельд холбогдсон бөгөөд сумдууд шилэн кабел ашиглаж өндөр хурдаар буюу 4 жи-гээр интернэтэд холбогдож байна. Үүрэн телефоны сүлжээний хувьд юнител, мобиком бүх сумдад, скайтелын сүлжээ 11 сум /Цагаандэлгэр,Өлзийт сумдын сүлжээ ажиллахгүй байгаа/, жимобайл-14 суманд сүлжээтэйгээс юнител компани өөрийн сүлжээтэй Дэлгэрхангай сумаас бүх сумдад 4 жи технологи нэвтрүүлж хэрэглэгчиддээ өндөр хурдны интернет ашиглах боломжийг хангаж өгсөн байна.

Хүснэгт.10. Үүрэн телефоны сүлжээ

Сумд	Мобиком	Скайтел	Юнител	Жи-Мобайл
Дэлгэрцогт	2жи	3жи , 2жи	4жи	3 жи
Дэрэн	2жи	3жи , 2жи	4жи	2жи
Говь-Угтаал	2жи	3жи , 2жи	4жи	3жи
Цагаандэлгэр	2жи	-	4жи	2жи
Баянжаргалан	2жи	3жи , 2жи	4жи	2жи
Өндөршил	3жи	3жи , 2жи	4жи	2жи
Гурвансайхан	2жи	3жи , 2жи	4жи	-
Өлзийт	2жи	-	4жи	3жи
Хулд	2жи	3жи , 2жи	4жи	3жи
Луус	2жи	3жи , 2жи	4жи	2жи
Дэлгэрхангай	2жи	-	2жи	2жи
Сайхан-овоо	2жи	-	4жи	3 жи
Эрдэнэдалай	3жи	3жи , 2жи	4жи	3 жи
Сайнцагаан	3жи	3жи , 2жи	4жи	3жи
Адаацаг	2жи	3жи , 2жи	4жи	2 жи

Холбооны салбарын мэдээгээр 2017 онд тарифын орлого 433.8 сая төгрөг болж өмнөх онтой харьцуулахад 18.5 хувиар өссөн байна. Интернэт цэгээр үйлчлүүлэгчдийн тоо 4665 болж өмнөх онтой харьцуулахад 50 хувиар буурсан бол суурин телефон цэгийн тоо 518 болж мөн 19.1 хувиар буурчээ.

Хүснэгт.11. Холбооны мэдээ

Үзүүлэлт	Хэмжих нэгж	2013	2014	2015	2016	2017	2017 /2016
Тарифын орлого	сая.төг	259.217	325.203	428.6	366.4	433.8	118.4
Үүнээс хүн амын	сая.төг	76.812	99.35	88.6	85.3	74	86.8
Суурин телефон цэг	тоо	695	686	647	640	518	80.9
Интернет цэгийн үйлчлүүлэгчдийн тоо	тоо	10884	13573	9863	9329	4665	50.0

4.Бүртгэлтэй аж ахуй нэгж

Статистикийн хэлтсийн бизнес регистрийн санд 2017 оны байдлаар аймгийн хэмжээнд нийт 965 аж ахуй нэгж бүртгэлтэй байгаагаас 138 төсөвт байгууллага, 158 төрийн бус байгууллага, 21 төрийн болон орон нутгийн өмчит үйлдвэрийн газар, 648 ААНБ байна.


Хүснэгт.12.Бизнес регистрийн санд бүртгэлтэй аж ахуй нэгж байгууллагууд, үйл ажиллагаа эрхлэлтийн байдлаар, сумаар

Сумын нэр	Үйл ажиллагаа явуулж байгаа	Үйл ажиллагаа эхлээгүй байгаа	Үйл ажиллагаа түр зогсоосон	Үйл ажиллагаа бүрэн зогсоосон	Бусад	Дүн
Сайнцагаан	324	100	96	14	1	535
Говь-Угтаал	18	2	3			23
Гурвансайхан	22		5	1		28
Дэлгэрхангай	24	4	3	4		35
Дэлгэрцогт	20	3				23
Дэрэн	15	4	1	2		22
Луус	19	2				21
Өлзийт	21	5	5	1		32
Өндөршил	25	3	12	1		41
Сайхан-Овоо	30	1	4		1	36
Хулд	28	4	6	1		39
Адаацаг	23	4	5	2		34
Цагаандэлгэр	14	5				19
Эрдэнэдалай	37	3	8	1		49
Баянжаргалан	19	7	1	1		28
Дүн	639	147	149	28	2	965

Нийт ААН-ийн 66.2 хувь нь буюу 639 ААН, байгууллага идэвхтэй үйл ажиллагаа явуулж байна. Бизнес регистрийн санд бүртгэлтэй нийт ААНБ болон үйл ажиллагаа идэвхтэй явуулж байгаа ААНБ-н тоог сүүлийн 5 жилээр графикт харууллаа. /Зураг.9/

Зураг.9

2017 онд Бизнес регистрийн санд бүртгэлтэй ААН, үүнээс үйл ажиллагаа явуулж байгаа ААН-н тоо



Үйл ажиллагаа тогтмол явуулж байгаа аж ахуй нэгж байгууллагуудыг эдийн засгийн салбараар нь авч үзвэл 30.8 хувийг бөөний болон жижиглэн худалдаа, 10.6 хувийг үйлчилгээний бусад үйл ажиллагаа, 7.8 хувийг боловсролын салбар тус тус эзэлж байна. Дэлгэрэнгүйг /Зураг.10/-т харууллаа.

Зураг.10

Үйл ажиллагаа явуулж байгаа аж ахуй нэгж байгууллага/эдийн засгийн салбараар, хувиар,2017 он/



5.Дотоодын нийт бүтээгдэхүүн/ДНБ/

ДНБ нь тухайн нутаг дэвсгэрийн хүрээнд дотоод гадаадын аж ахуй нэгж, байгууллага, иргэдийн нэг жилийн хугацаанд шинээр бий болгосон нийт нэмэгдэл өртгийн хэмжээ юм. ДНБ-ийг үйлдвэрлэлийн, эцсийн ашиглалтын, орлогын гэсэн 3 аргаар тооцдог бөгөөд Аймгийн ДНБ-ийг Монгол улсын Үндэсний Статистикийн хорооноос харьяатын зарчмыг баримтлан тооцож байна. Аймаг бүсийн ДНБ-ийг үйлдвэрлэлийн болон орлогын аргыг хослуулан тооцдог.

2017 оны аймгийн дотоодын нийт бүтээгдэхүүн оны үнээр урьдчилсан гүйцэтгэлээр 252.5 тэрбум төгрөг болж өмнөх онтой харьцуулахад 11.7 хувиар буюу 26.4 тэрбум төгрөгөөр өссөн байна. Аймгийн ДНБ-ийг бусад говийн бүсийн аймгуудтай харьцуулан жилээр хүснэгтэд харууллаа.

Хүснэгт.13.Аймгийн ДНБ /говийн бүсийн аймгууд,сая.төг/

Аймаг	2013	2014	2015	2016	2017	2017/2016
Дорноговь	273119	308754	261319.1	272288.4	299574.5	110.0
Дундговь	179401.0	213115.0	237565.8	226072.5	252499.2	111.7
Өмнөговь	454724.4	335829.8	281273.5	404035.8	540349.3	133.7
Говьсүмбэр	57641.5	72860.8	83724.4	83354.9	87255	104.7

2017 оны ДНБ-ий бүтцийг салбараар авч үзвэл ХАА-н салбар 58.5 хувь, Аж үйлдвэр, барилгын салбар 13.4 хувь, Худалдаа үйлчилгээний салбар 28.1 хувийг тус тус эзэлж байна. ДНБ-ийг сүүлийн 5 жилээр салбарын бүтцээр харууллаа.


Хүснэгт.14. Аймгийн ДНБ сүүлийн 5 жилээр, салбарын бүтцээр

	2013	2014	2015	2016	2017*
Нийт ДНБ/сая.төг/	179401	213115	237565.8	226072.5	252499.2
Хөдөө аж ахуй/эзлэх хувь/	60.6	61.0	60.1	55.1	58.5
Аж үйлдвэр, барилга/эзлэх хувь/	11.9	10.4	11.9	14.2	13.4
Худалдаа үйлчилгээ/эзлэх хувь/	27.5	28.6	28	30.7	28.1
Нийт хувь	100.0	100.0	100.0	100.0	100.0

Аймгийн 1 хүнд ногдох ДНБ 2016 онд 4995.5 мянган төгрөгт хүрсэн байгаа нь өмнөх оны үзүүлэлтээс 8.3 хувиар өссөн үзүүлэлт юм. Мөн энэ нь 21 аймгийн нэг хүнд ногдох ДНБ-ээрээ 7 дугаарт эрэмбэлэгдсэн байна. Зурагт аймгийн нэг хүнд ноогдох ДНБ-ийг Улсын дундаж болон говийн бүсийн аймгуудтай зэрэгцүүлэн харууллаа. /Зураг.11/

Зураг.11

Нэг хүнд ногдох ДНБ /мян.төг,2016 оны гүйцэтгэлээр/



Дүгнэлт

2017 онд аж үйлдвэрийн бүтээгдэхүүн үйлдвэрлэлт өмнөх онтой харьцуулбал 12.0 хувиар буюу 864.7 сая төгрөгөөр өсч 8097.8 сая төгрөгт хүрсэн байна. Дээрх өсөлтөнд дулааны эрчим хүч үйлдвэрлэл, усан хангамж үйлдвэрлэл өмнөх онтой харьцуулбал 24.3 хувиар өссөн нь голлон нөлөөлсөн байна. Мөн тухайн онд өмнөх онтой харьцуулбал боловсруулах аж үйлдвэрийн салбар 1.5 хувиар, уул уурхайн олборлох салбар 3 хувиар тус бүр өссөн байна.

Тус аймагт 2017 онд 8003.1 сая төгрөгийн бүтээн байгуулалт, их засварын ажил хийгдсэн нь өмнөх онтой харьцуулбал 27.9 хувиар буурсан байна. Энэ онд 5517.6 сая төгрөгийн барилга угсралтын ажил, 2485.5 сая төгрөгийн их засварын ажил хийжээ.

2017 оны байдлаар зорчигч тээвэр 29.3 мянга болж өмнөх оноос 32.9 хувиар буурч, зорчигч эргэлт мөн 32.8

хувиар буурч 8059.5 мян.хүн.км болсон байна. Зорчигч тээврийн орлого 31.6 сая төгрөг болж өмнөх оноос 2.6 хувиар буурсан байна.

Холбооны салбарын мэдээгээр 2017 онд тарифын орлого 433.8 сая төгрөг болж өмнөх онтой харьцуулахад 18.5 хувиар өссөн байна. Интернет цэгээр үйлчлүүлэгчдийн тоо 4665 болж өмнөх онтой харьцуулахад 50 хувиар буурсан бол суурин телефон цэгийн тоо 518 болж мөн 19.1 хувиар буурчээ.

2017 оны аймгийн дотоодын нийт бүтээгдэхүүн оны үнээр урьдчилсан гүйцэтгэлээр 252.5 тэрбум төгрөг болж өмнөх онтой харьцуулахад 11.7 хувиар буюу 26.4 тэрбум төгрөгөөр өссөн байна.

Аймгийн 1 хүнд ногдох ДНБ 2016 онд 4995.5 мянган төгрөгт хүрсэн байгаа нь өмнөх оны үзүүлэлтээс 8.3 хувиар буурсан үзүүлэлт юм. Энэ нь 21 аймгийн нэг хүнд ногдох ДНБ-ээр 7 дугаарт эрэмбэлэгдсэн байна. Аймгийн нэг хүнд ноогдох ДНБ-ийг Улсын дундаж болон говийн бүсийн аймгуудтай харьцуулахад Өмнөговь аймаг манайхаас өндөр, харин Дорноговь, Говь-Сүмбэр аймгууд манай аймгаас доогуур эрэмбэлэгдсэн байна.

Ашигласан ном материал

1. Монгол улсын статистикийн эмхэтгэл 2013-2017
2. Аймгийн нийгэм эдийн засгийн танинцуулга 2013-2017
3. Дундговь аймгийн товч түүх 1991 он
4. Аймгийн БР сан 2012-2015
5. www.nso.mn
6. www.1212.mn

Хамтран ажилласан

Хүнс хөдөө аж ахуйн газрын жижиг дунд үйлдвэрлэл хариуцсан мэргэжилтэн Ж.Мөнхбаяр

Хөгжлийн бодлогын хэлтсийн уул уулрхй хариуцсан мэргэжилтэн П.Очирбат



Танилцуулга бэлтгэсэн: Ахлах мэргэжилтэн
Т.Бямбасүрэн

Утас: 88593456

Факс: 70593715,

И-мэйл: dundgovi@nso.mn

Хаяг: Дундговь аймгийн Засаг даргын тамгын газар
319,320 тоот

2018 оны 06 сарын 15

ХЯНАСАН: ДУНДГОВЬ АЙМГИЙН СТАТИСТИКИЙН
ХЭЛТСИЙН ДАРГА Б.ЭНХТУЯА